

**2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 16-НЫ ӨДРИЙН ДҮҮРГИЙН УДИРДАХ
АЖИЛТНУУДЫН ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР ЗАСАГ ДАРГААС
ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР**

Дүүргийн шуурхайн үүргийн биелэлтийг Агаал-12 фонтоор бичиж, 2023 оны 01 сарын 26-ны өдрийн 17.00 цагаас өмнө файл болон цаасан хэлбэрээр баталгаажуулан Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (ЕРП Б.Одбаяр)-т ирүүлнэ үү. Хугацаа хэтэрсэн тохиолдолд биелэлт ирүүлээгүйд тооцно.

| № | Өгсөн үүрэг даалгавар | Хариуцах эзэн |
|---|---|---------------------------|
| НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР | | |
| БОДЛОГЫН ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | |
| 1. | 2023 онд нийслэлд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь чанартай гүйцэтгэх, санхүүжилтийн үйл ажиллагааг төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон холбогдох журамд нийцүүлэн ил тод шуурхай, зохион байгуулж, хүнд суртал гаргахгүй байх. | СТСХ ХААА |
| 2. | Хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын хүрээнд хийгдсэн ажлуудын худалдан авах ажиллагааны болон холбогдох мэдээллийг олон нийтэд ил тод мэдээлэх. | СТСХ ХААА |
| 3. | Газар олголт, зөвшөөрөлтэй холбоотой жагсаалт гаргах, цаашид цэгцлэх ажлуудын талаарх санал боловсруулж танилцуулах. | ГЗБА |
| 4. | Байгаль орчны сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх зорилгоор саарал усны шинэ технологийг нэвтрүүлэх талаар санал боловсруулж танилцуулах | ТХҮХ УСАТ |
| 5. | 2023 онд гадаад харилцаа хамтын ажиллагааны чиглэлээр хийгдэх гадаад айлчлалуудын бэлтгэл ажлуудыг хангах. /БНХАУ, Япон улс/ | ТЗУХ |
| 6. | Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний бэлтгэл ажлыг шуурхай зохион байгуулах хүрээнд газар олголтын асуудлыг шийдвэрлэн, газрын гэрчилгээ олгох, гэрээ байгуулах, нөхөх олговортойгоор газар чөлөөлөх, чөлөөлсөн газрыг нийтийн эдэлбэр газарт бүртгэж авах зэрэг бэлтгэл ажлыг сайтар хангах. | ГЗБА |
| 7. | Мэргэжлийн байгууллага хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулж, тулгамдсан асуудлыг тухай бүр шийдвэрлэх, хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлийн бүхий л үе шатанд тавих хяналтыг сайжруулах | СТСХ ХААА |
| 8. | Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын чиг үүргийг салбарын байгууллагуудад шилжүүлсэнтэй холбогдуулж нийслэлийн иргэдийн эрүүл, аюулгүй орчныг хангах үүднээс дүүрэгт байцаагч ажиллуулах талаар холбогдох газарт уламжлах | ЗДТГ |
| 2022-2023 ОНЫ ӨВӨЛЖИЛТИЙН АЖЛЫН ХҮРЭЭНД: | | |
| 9. | Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудаас инженерийн шугам сүлжээний засвар үйлчилгээний талаар | ТХҮХ, Илч-Орд ОНӨААТҮГ |

| | | |
|--|---|--|
| | ирүүлж буй өргөдөл, гомдлыг түргэн шуурхай шийдвэрлэх, иргэдийг ус, дулаан, цахилгаан эрчим хүчээр найдвартай хангахад онцгой анхаарч, машин механизм, техник тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангаж ажиллах. | УСАТ |
| 10. | Хот нийтийн аж ахуй, инженер хангамжийн чиглэлээр ажлын байранд тавигдах хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандартыг хангах, ажилтан, хөдөлмөр эрхлэгч иргэнийг эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлэх. | ТХҮХ Дэд бүтцийн байгууллагууд |
| АЖЛЫН САХИЛГА, ХАРИУЦЛАГА, ДЭГ ЖУРМЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД: | | |
| 11. | Албан хаагч бүр ажил, албан тушаалаа хэрэгжүүлэхдээ Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хориглолт хязгаарлалтыг зөрчихгүй байхад анхаарах | ТЗУХ ААНБ |
| 12. | Төрийн албаны тухай хууль тогтоомж, холбогдох дүрэм, журам, заавар, зөвлөмжийн дагуу байгууллагын үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүнг сайжруулах, төрийн албаны стандартыг мөрдөж ажиллах. | ТЗУХ ААНБ |
| 13. | Иргэдэд хүнд суртал, чирэгдэл, ёс зүйн доголдол гаргахгүй үйлчлэх, байгууллага бүр Ёс зүйн хорооныхоо үйл ажиллагааг идэвхжүүлж, зөрчил гаргасан албан хаагчдад хариуцлага хүлээлгэн, зохих журмын дагуу холбогдох байгууллага, иргэд, ажилтнууддаа мэдээлдэг байх. | ААНБ |
| ЦАГ ҮЕИЙН АСУУДЛЫН ХҮРЭЭНД | | |
| 14. | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу төрийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр явуулах, нээлттэй, ил тод, шуурхай байлгах, цахим хуудас мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлж ажиллах. | ТЗУХ ААНБ |
| 15. | Дүүргүүд оны эхнээс төсвийн орлогын бүрдүүлэлтийг эрчимжүүлэх, татварын орлогын бааз суурийг өргөжүүлж ажиллах. | СТСХ Татварын хэлтэс |
| 16. | Зөвшөөрлийн тухай хуулийг хэрэгжүүлэх, хуульд заасан хугацаа, болзол, журмыг мөрдөх, иргэн, хуулийн этгээдийн хүсэлтийг хуулийн дагуу хянан шийдвэрлэх, албан хаагчдыг сургах, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллах. | ТХҮХ Холбогдох ААНБ-ууд |
| 17. | Хотын стандарт, норм, дүрмийн талаарх мэдлэг ойлголтыг аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд хүргэх замаар тэдний үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэн, хотын стандартыг мөрдүүлэхэд бүх нийтийн оролцоог хангуулж ажиллах. | ТХҮХ |
| 18. | 2023 онд гэр хорооллын доторх ногоон байгууламж бүхий цэцэрлэгжсэн талбайн хэмжээг нэмэгдүүлэхэд анхаарах, аж ахуйн нэгж иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, мод сөөгийн нэр төрлөөр нь тооллого | ТХҮХ Багахангай гэрэлтүүлэг ОНӨААТҮГ |

| | | |
|---|--|------------------|
| | бүртгэлийн суурь мэдээллийн санг бий болгох, ногоон байгууламж нэмэгдүүлсэн талбайг байнгын арчилгаатай байлгахад анхаарч ажиллах. | |
| 19. | 2023 онд хийгдэх явган хүний зам, дугуйн зам, ногоон байгууламжуудын техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах бэлтгэл ажлыг хангаж ажиллах. | ТХҮХ |
| ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР | | |
| 20. | 2023 оныг “Иргэдийн оролцоо, сахилга хариуцлагыг дээшлүүлэх жил” болгон зарласантай холбогдуулан үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, ААНБ-ууд санал өгөх, иргэдийн оролцоог хангах, дэмжиж ажиллах чиглэлээр ажил зохион байгуулж ажиллах | ТЗУХ ААНБ-ууд |
| 21. | Сайжруулсан шахмал түлш хэрэглэх бүсэд хамрагдах эсэх талаар хороодод агаарын чанарын хэмжилт хийлгэх ажлыг зохион байгуулах | ТХҮХ |
| 22. | Нийслэлээс эрх шилжиж ирэх 5 ажлын албан бичгийг холбогдох газарт хүргүүлж, 1 дүгээр сардаа багтаан үнэлгээний хороо байгуулах, техникийн тодорхойлолт боловсруулах | ЗДО ХААА |